



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/90

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 09 дүгээр зөвлөмжийн дагуу Хархорин, Хужирт сумдын 75 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээг 30000000 (Гучин сая) төгрөгөөр “Барилга байгууламж” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

1. Гэрээ байгуулж, зураг төсөв боловсруулах хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

2. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100210